

Цахим Орчинд Хүүхдийг Хамгаалах Хуулийн Төслийг Дагалдуулан Эрүүгийн Хуулинд Өөрчлөлт Оруулах Саналууд

Д. Тэнгис
tengis@lantuundohio.org
Lantuun Dohio USA, NGO

Б. Тамир
tamir@lantuundohio.org
Лантуун Дохио, ТББ

6.1 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх

2. Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн энэ хуулийн тусгай ангийн 10.1/Хүнийг алах/, 11.1/Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1/Хүчиндэх/, 14.1/Ялгаварлан гадуурхах/, 16.8 /Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах/, 16.9 /Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах/, 17.1/Хулгайлах/, 17.2/Дээрэмдэх/, 17.8/Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16/Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Кибер орчинд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8/Террор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх

1. Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа; кибер орчныг ашиглаж хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох

1. Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.1. Энэ гэмт хэргийг:

1.1.1. бусдаар зуучлуулж, шан харамж өгч;

1.1.2. урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.1.3.хохирогчийн итгэлийг олж, гэр бүлийн байдал, амьдрал ахуйн орчин, төрөл, садангийн байдлыг далимдуулан; кибер орчныг ашиглан удаа дараа,тогтвортой үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар шийтгэнэ.

Тайлбар: Child grooming гэх ойлголтыг тодорхойлж, тохирох ялыг оноох шаардлагатай байна.

12.6 дугаар зүйл.Биеэ үнэлэхийг зохион байгуулах

1.Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.1.энэ гэмт хэргийг кибер орчныг ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.2.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

14.1 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхах

1.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

[/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

2.Энэ гэмт хэргийг:

2.1.бүлэглэж;

2.2.хүч хэрэглэж;

2.3.кибер орчныг ашиглаж;

2.34.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж; **гэр бүлийн хамаарал бүхий харилцааны хүн** үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.8 дугаар зүйл.Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах

1.Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; ~~хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэж, бэлгийн харьцаанд өрөхыг санал болгосон~~ бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.1.энэ хэргийг:

1.1.1.кибер орчныг ашиглаж;

1.1.2.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.1.3.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Хүүхдээр эротик, бэлгийн дур хүслийг өдөөх зорилготой үйлдэл хийлгэсэн бол гурван сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.1.энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.2.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.1.энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.9 дүгээр зүйл.Хүүхэд оролцуулж, садар самууныг сурталчлах

~~1.Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.~~

~~2.Энэ гэмт хэргийг:~~

~~2.1.кибер орчныг ашиглаж;~~

~~/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./~~

~~2.2.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дочин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.~~

1.Хүүхдийн гэрэл зураг, дуу, дүрс болон бусад эмзэг мэдээллийг ашиглаж, эсхүл хүүхдийг оролцуулж, хүүхдийн тусламжтайгаар садар самууныг сурталчилсан, эротик хэвлэл, ном зохиол, бичвэр, зураг, кино, дуу, дүрс бичлэг, бусад зүйлийг **санаатайгаар хүлээн авсан, хадгалсан,**

олшруулсан, нэвтрэх эрх авсан, эзэмшсэн хүнд дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлана, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: хүүхэд хамгаалах эрх бүхий төрийн байгууллага, хууль хүчний байгууллагад мэдээлэх зорилгоор гурваас бага тоогоор хүлээн авсан, хадгалсан, олшруулсан, нэвтрэх эрх эзэмшсэн бол ял шийтгэл оногдуулахгүй.

2.Хүүхдийн гэрэл зураг, дуу, дүрс болон бусад эмзэг мэдээллийг ашиглаж, эсхүл хүүхдийг оролцуулж, хүүхдийн тусламжтайгаар садар самууныг сурталчилсан, эротик хэвлэл, ном зохиол, бичвэр, зураг, кино, дуу, дүрс бичлэг, бусад зүйлийг **санаатайгаар дамжуулсан, илгээсэн, тараасан, сурталчилсан** бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлана, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.1.энэ гэмт хэргийг:

2.1.1.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл гурван сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.1.2.кибер орчныг ашиглаж үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.1.3.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Хүүхдийн гэрэл зураг, дуу, дүрс, хувийн эмзэг мэдээллийг ашиглаж, эсхүл хүүхдийг оролцуулж, хүүхдийн тусламжтайгаар садар самууныг сурталчилсан, эротик хэвлэл, ном зохиол, бичвэр, зураг, кино, дуу, дүрс бичлэг, бусад зүйлийг **борлуулсан** бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.1.энэ гэмт хэргийг:

3.1.1.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.1.2.кибер орчныг ашиглаж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.1.3.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Хүүхдийн гэрэл зураг, дуу, дүрс болон бусад эмзэг мэдээллийг ашиглаж, эсхүл хүүхдийг оролцуулж, хүүхдийн тусламжтайгаар садар самууныг сурталчилсан, эротик хэвлэл, ном зохиол, бичвэр, зураг, кино, дуу, дүрс бичлэг, бусад зүйлийг **бэлтгэсэн**; эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн хамаарал бүхий хүн нь **бэлтгэхийг зөвшөөрсөн**, мэдсээр байж энэ гэмт хэргийг таслан зогсоогоогүй эс үйлдэхүйд таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.1.энэ гэмт хэргийг:

4.1.1.урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;

4.1.2.бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.